

Азийн орнуудын англи хэлний тархалт ба хөгжил

Намсрайжавын Мөнхбаяр 

Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургуулийн
Англи хэлний тэнхимийн ахлах багш, доктор (Ph.D), Улаанбаатар, Монгол Улс

Хүлээн авсан - Received:
2023-11-15

Засварласан - Revised:
2023-12-17

Хэвлэгдсэн - Published:
2023-12-26

munkhbayar@msue.edu.mn

ORCID:[0009-0007-4457-6561](https://orcid.org/0009-0007-4457-6561)



© 2023, Author(s)

Хураангуй: Тус өгүүлэлдээ Сингапур, Филиппин, Хон Конг, Хятад, Малайз, Тайван, Япон, Солонгос зэрэг Азийн орнуудын англи хэлний тархалт (Качру, 2009) болон түүхэн замнал, англи хэлний сургалтад баримталж буй бодлого, цаашдын чиг хандлага зэргийг дэлгэрэнгүй судалж үзэхийг хичээлээ. Энэ нь өөрийн орны англи хэлний боловсролын үүргийг тодорхойлох, ирээдүйн чиг хандлагыг тогтооход чухал үүрэгтэй билээ.

Түлхүүр үг: Азийн орнуудын англи хэлний хөгжил, бодлогын шинж чанар, боловсролын үүрэг, ирээдүйн чиг хандлага

Удиртгал

Англи хэлийг өдөр тутмын албан ёсны хэлний үүргээр хэрэглэдэг орнуудад Энэтхэг, Малайз, Сингапур зэрэг улсуудыг хамруулж болох ба бүгд олон үндэстэний, олон хэлний соёлыг баримтлагч улсууд юм. Англи хэл дээрх улсуудын нийгэмд нэвтрэх үйл явцын дунд Энэтхэгийн англи хэл, Малайзын англи хэл, Сингапурын англи хэл гэх зэргээр англи хэлний хувилбарууд гарч ирсэн ба бүгд өөрийн гэсэн хэлбэр болон хэрэглээний хэм хэмжээтэй болжээ.

Англи хэлийг олон улсын хэлний зориулалтаар ашигладаг, заадаг, сурдаг орнуудыг урьд нь англи хэлийг гадаад хэлний зориулалтаар эзэмшдэг улс (EFL) гэж нэрлэдэг байсан. Эдгээр орнуудын ихэнх нь англи хэлийг олон улсын харилцааны хэл, олон улсын соёлын ойлголцлын хэл гэдгийг таньж мэдсэн учраас онцлон үздэг. Англи хэлийг олон улсын харилцааны хэл хэмээн үздэг орнуудад Европын холбооны улс, Турк, Тайланд, Иран, Хятад, Солонгос, Бразил зэрэг орнуудыг багтаан оруулдаг байна.

Зүүн Өмнөд Азийн 10 орон, түүнчлэн Хятад, Япон, Солонгосыг оролцуулаад англи хэлээр ярьдаг 450 сая хүн, Европчуудын 38% нь англи хэлээр ярьдаг, НҮБ-ийн 126 орны 95% нь албан хэргийн баримт бичгүүдээ англи хэл дээр хүлээн авдаг, олон

улсын байгууллагын 85% нь англи хэлээр үйл ажиллагаагаа явуулдаг, дэлхийн 80 гаруй оронд тусгай статусаар судлагдаж байгаа зэргээс үзэхэд англи хэл дэлхийн нийтийн *глобаль* хэл болсон. (Маржори Фрайдман/Friedman, 2014) 2050 он гэхэд дэлхийн хүн амын бараг хагас хувь буюу 3 тэрбум хүн англи хэлийг ямар нэг хэмжээгээр эзэмшсэн байна гэсэн тооцоо байгаа ажээ. (<http://en.wikipedia.org/wiki/English>)

Бангладеш, Камбож, Хятад, Индонез, Япон, БНСУ, Тайланд зэрэг улсын дээд сургуулиудад англи хэлийг өндөр түвшинд үздэг, “шинжлэх ухааных нь хэл” болсон тул хүн амынх нь тодорхой хэсэг англи хэлийг харилцааны хэрэгслийнх нь хувьд зохих хэмжээнд мэдэж, олон улсын харилцаанд энэ хэлийг өндөр түвшинд ашигладаг орнууд юм. Судалгаанаас үзэхэд Азийн Япон, БНСУ, БНСВУ, түүнээс гадна Баруун Ази, арабын ертөнц тэр чигээрээ өөрийн үндэсний хэл, бичгийн зэрэгцээ англи хэлийг албан ёсны *олон улсын харилцааныхаа хэл* бичиг болгож авсан байна.

Австрали, Күүкийн арлууд, Фижи, Филиппин, Энэтхэг, Шинэ Зеланд зэрэг орон англи хэлийг төрийн албан ёсны хэл болгосон төдийгүй эдгээр орны бүх шатны сургуулиудад сургалтыг англи хэлээр явуулдаг байна. Англи хэл сургалтын хэл болсон олон улсын их, дээд сургуулиудын оюутнуудын хувьд Германы англи хэл (Denglisch), Хятадын англи хэл (Chinglish), Сингапурын англи хэл (Singlish) зэрэг англи хэлний шинэ хувилбарууд үүсээд байгаа ба дэлхий дахины ярианы англи хэлний стандарт хувилбар (WSSE-World Standard Spoken English)-ыг баримтлах нь зүйтэй гэж үзэх болсон. Энэ нь нутгийн аялгууны нөлөөлөлд автсан унаган англи хүмүүст ч гэсэн хамаатай байна.

Англи хэлийг хоёрдогч хэлээ болгон үзэж судалдаг улс орнуудын англи хэлний сургалтын бодлого, чанарыг дээшлүүлж, технологийг өөрчлөх олон талт үйл ажиллагааг хэрхэн явуулж байгаа талаар судалгаа хийхдээ манай оронтой ижил соёлтой, Ази номхон далайн бүс нутаг дахь, мэргэжлийн англи хэлний сургалт илүү хөгжсөн Энэтхэг, Вьетнам, Малайз, Сингапур, Тайван, Хятад, Япон, Солонгос зэрэг орнуудыг сонгон авч үзэв.

Энэтхэг улс эдийн засгийн өсөлтөө өрсөлдөхүйц хэмжээнд хүргэхийн тулд улс төр болон эдийн засгийн шинжээч нар нь англи хэлний өндөр чадвар эзэмшихэд ач холбогдол өгдөг. (Tollefson, W. 2013). Хятад улс нь Энэтхэг улсаас англи хэлээр ярьдаг хүнийхээ тоогоор илүү гардаг. Энэ айдас нь англи хэлний бодлогын түвшинг улсын хэмжээнд авч үзэхэд хүргэж эдийн засгийн дахин сэргэлтэд хүрэх дараагийн алхам нь иргэдийнхээ англи хэлний мэдлэгийг өргөжүүлэх, дээшлүүлэх явдал мөн гэж тодорхойлжээ. (Graddol, D. 2010). Өнөөгийн баримталж буй бодлогын хувьд англи хэл нь маргаангүй мэдээлэл, мэдлэг хүртэх гол хэрэгсэл төдийгүй бизнесийн орчинд харилцах хэл дэлхийг харах цонх, түүнд хүрэх хаалга хэмээн үздэг. Англи хэл нь дипломат харилцааны хэл, гүйцэтгэх засаглалийн хэл, дээд боловсролын хэл, дээд шүүхийн хэл, мэдээллийн технологийн хэл болсон байна. Тус хэлийг ямар

зориулалтаар сурах гэж байгаагаас хамаараад Энэтхэг улсад мэргэжлийн англи хэлийг 3 хэв шинжид хуваан авч үздэг:

- EAP (English for academic purposes) Академик англи хэл
- EOP (English for occupational purposes) Ажил мэргэжлийн англи хэл
- ESP (English for specific purposes) Мэргэжлийн англи хэл

2003 онд аж үйлдвэрийн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүн 52% өссөн бөгөөд ажиллагсадын 28% нь мэдээлэлийн технологийн үйлчилгээ, эдийн засгийн салбарт хамаарсан ба англи хэлний онцгой чадварыг шаарддаг. (Verna, R. 2008). Бусад үйлчилгээний салбар болох тээвэр, аялал жуулчлалд англи хэлний харилцааны чадварыг шаарддаг байхад үлдсэн 72% нь болох бараа үйлдвэрлэл, худалдаа, барилга, нэхмэл, гар урлал, хөдөө аж ахуй зэрэгт тус хэлний чадварыг тийм ч ихээр онцолж үздэггүй байна.

Вьетнамын дээд боловсролын системд Англи, Орос, Хятад, Франц, Герман гэсэн 5 хэлийг судалдаг ба бакалаврын түвшиний 94%, бакалаврын дараах сургалтын 92% нь англи хэлийг танхимд судалдаг. Ажлын байрны олоц нь хэр зэрэг сайн англи хэлтэй байхаас хамаардаг учир дээд сургуулийн оюутнууд англи хэл сурах илүү их тэмүүлэлтэй байдаг. Математик, физик, хими зэрэг үндсэн хичээлүүдийг англи хэлээр заадаг дээд боловсролын сургуулиудыг дэмжих бодлого баримталдаг. Канадад боловсруулсан ном сурах бичгийг сургалтанд ашигладаг, багш боловсон хүчээ Британд бэлтгэдэг, Вьетнамын засгийн газраас хөтөлбөрийг нь боловсруулж өгдөг байна. (Барбара Е Жеймс. 2009)

Малайзын мэргэжлийн англи хэл 40 жилийн түүхтэй. Малайзын Их сургуулийн мэргэжлийн англи хэлний төсөл 1970 оны сүүлээр хэрэгжсэн нь мэргэжлийн англи хэлний эхлэлийг тавьсан гэж үздэг. (*ELT Documents 107: University of Malaya ESP Project*, 1980 for details of the project).

Энэ төслийн хүрээнд Их Британи Улсын зөвлөхүүдийн тусламжтайгаар мэргэжлийн англи хэлний багш мөн мэргэжлийн англи хэлний сурах бичгүүдтэй болсон. Малайзын Технологийн их сургуульд Британий консул Барилгын инженерийн англи хэлний төслийг санаачилсан. *Гэрээ хэлэлцээр хийхэд зориулагдсан англи хэл*-ийг Их Британийн Жонн Плаймөүд ба Рэй Вилламс нартай хамтран хэрэгжүүлсэн. (Rajagopal, M., & Williams, R. 1995).

1992 оны 2 сард Боловсролын Яамны тусгай мэргэжлийн боловсролын хорооноос политехникийн дээд сургуулиудад мэргэжлийн англи хэлний шинэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх шийдвэр гаргасан. Ийнхүү мэргэжлийн англи хэлний хичээлийн хөтөлбөрийг 8 жилийн турш хэрэгжүүлэх үйл ажиллагааг явуулсаны үр дүнд тус хөтөлбөр бүрэн утгаараа хэрэгжсэн гэж үзсэн. Ажлын байрны хэрэгцээ шаардлагатай уялдуулан ээлж дараалсан судалгааны төслүүдийг хэрэгжүүлдэг байна. Тухайлбал инженерийн фирмийн 50 хүнээс хэлний хэрэгцээ шаардлагын судалгаа, инженерүүдийн нөхцөл байдлыг ойлгохын тулд 11 инженерийн илтгэлийн анализыг

хийсэн байх жишээтэй. Англи хэлний багш нар нь Малайз дахь Японы цахилгааны компанид туслах ажилтанаар 10 долоо хоног ажиллаж тэдний хооронд хэрэглэгдэж буй дискурсийг судалсан байна. Мөн Малайзад байдаг Америкийн компанид ажиллаж техникийн үг хэллэгийг судалдаг.

Засгийн газраас явуулж буй хамгийн шуугиан тарьсан хөтөлбөр нь 2003 оноос эхэлж бүх шатны сургуулиудад математик болон шинжлэх ухааны хичээлүүдийг англи хэл дээр явуулж англи хэлийг сургалтын хэл болгосон явдал юм. 2020 он гэхэд Малайз улс нь олон улсын харилцааны технологийн (ICT) дэвшилтэт түвшинд хүрсэн үндэсний төслийг хэрэгжүүлсэн байна гэсэн алсын хараатай ажиллаж байгаа ба үүнд хүрэх үндсэн түлхүүр нь англи хэлний сургалт (ELT) хэмээн үзжээ.

Сингапур бол олон үндэстэний, олон соёлын, олон хэлний орон юм. Сингапурын хэлний бодлогын хамгийн өвөрмөц хэв шинж нь англи хэлийг нэгдүгээр хэл гэж авч үздэг явдал юм. Сингапурын хүн ам ихэнхдээ Хятад, Малайз, Энэтхэгчүүдээс бүрддэг ба албан ёсны хэлнүүд нь Англи хэл, Мандарин, Малай болон Тамил юм. Сингапурын засгийн газар нь зориудаар англи хэлийг албан ёсны нэгдүгээр хэл хэмээн үзэхийн зэрэгцээ англи хэлийг олон улсын ажлын байрны хэл гэж тодорхойлж үүний үр дүнд Сингапур улс дэлхийд тэргүүлэх олон үндэстэний бизнесийн улс болж хөгжсөн байна. Албан захидал болон засгийн газрын албан бичиг баримтууд, бизнесийн гэрээ, олон нийтийн тэмдэг тэмдэглэгээнүүд нь англиар бичигддэг. Төрөлх хэлнээс бусад бүх хичээлүүд англи хэл дээр заагддаг. Сингапурын англи хэлний бодлого нь нийгэм түүхийн, нийгэм соёлын, нийгэм улс төрийн дүн шинжилгээг хэл төлөвлөлтийн бодлогодоо тусган оруулах гэсэн үзэл санааг баримталдаг.

Тайвани улс англи хэлний сургалтаараа Азийн шилдэг 5 орны нэгэнд багтдаг. Өрсөлдөөнт зах зээлийн системийн үед ажлын байраар хангах үүднээс их, дээд сургуулиудад нь мэргэжлийн англи хэлний төрөл бүрийн хичээлүүдийг зааж эхэлсэн. Үндэсний их сургуулиудын хувьд мэргэжлийн англи хэлний багш нарыг урьж ажиллуулах санхүүжилт сайтай байдаг. 2009 онд улсын хэмжээнд төрөлтийн тоо буурч 0.86% болж оюутнуудын тоо цөөрсөнтэй холбогдуулан мэргэжлийн англи хэлийг заах тухайд англи хэлний багш, тухайн мэргэжлийн багш нарын хооронд өрсөлдөөн бий болоод байна.

Хятад улсад өнөөгийн байдлаар академик түвшиний бизнесийн англи хэл хурдацтай хөгжиж байна. Америкийн нэгдсэн улсад хэвлэгдсэн олон тооны цуврал бизнесийн англи хэлний номнуудыг (“BEC”, “Зах зээлд тэргүүлэгч”) хэвлэж хэрэглэсээр байна. Хятадын 800 гаруй их дээд сургуулиудад бизнесийн англи хэлний анги нээгдээд байгаа ба сургах түвшин, мэргэжил, зэрэг, хөтөлбөрийн хувьд олон хувилбартай, төгсөгчид нь дотоодын болон олон улсын бизнесийн компаниудад ажилд орох нь түгээмэл байдаг байна. Бизнесийн англи хэл Хятад улсад 50 жилийн

туршид 7 үе шаттайгаар хөгжиж ирсэн ба 2007 онд Хятадын Боловсролын Яам бизнесийн англи хэлийг албан ёсны хичээл болгон баталжээ. (Wenzhong Zhu, 2011)

Солонгос улс нь Солонгосын дайны дараагаар хурдацтай хөгжиж ерөнхий хөгжлийн байдлаараа (GDP) 2009 онд дэлхийд 15-р байранд орсон байна. Хичээл зүтгэлтэй хүмүүс ийнхүү аж үйлдвэрийн өндөр хөгжилд хүрсэнийг Хан мөрний гайхамшиг хэмээн нэрлэдэг байна. Даяаршлын үеийн Солонгос улсад англи хэлний өндөр боловсролтой, гадаад соёлыг ойлгож чаддаг, олон улсад ажиллах чадвартай, идэвхтэй хүмүүс шаардлагатай байгаа ба энэ нийгэмд тэсэж үлдэхийн тулд засгийн газар нь англи хэлний боловсролыг онцлон үздэг. Бараг бүх Солонгос хүн англи хэлийг олон улсын хэл гэсэн түгээмэл ойлголттой байдаг учраас англи хэлийг эрчимтэй сурах асар их тэмүүлэлтэй болоод байна. (A series of Studies on English Education (13 Volumes), Volume 2. 2015.)

Япон улсад мэргэжлийн англи хэл сүүлийн хэдэн жил хурдацтай хөгжсөн. 1994 онд гарсан их сургуулиудын сургалтын хөтөлбөрийг хянах Момбушогийн (Mombusho) шийдвэр гарсан нь тус сургалтыг хөгжүүлэх түлхэц болсон байна. Үүний үр дүнд уламжлал болсон ерөнхий англи хэлний курсуудын оронд Химийн англи хэл гэх мэт тусгай зориулалтын англи хэлний курсуудын тоо нэн хурдацтай өсөн нэмэгдсэн байна. Боловсрол, Соёл, Спорт, Шинжлэх ухаан Технологийн Яамнаас 2007 онд “Англи хэлтэй Япон хүн” гэсэн нэртэй япон хүнийг англи хэлний чадвартай болгон хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны төлөвлөгөө гаргасан. Япон улсад ерөнхий англи хэл (EGP) ба мэргэжлийн англи хэл (ESP) хоёрыг хослуульж заах сургалтын бодлого болох 4-4-4 гэсэн загварыг хөгжүүлдэг.

Монгол улсын их сургуулиудын хувьд мэргэжлийн англи хэлийг судлах цаг бага, суралцагчийн болон нийгмийн хэрэгцээ шаардлагыг хөтөлбөрт тусгаагүй, мэргэжлийн англи хэлийг ерөнхий англи хэлнээс ялгаж өгсөн бодлогын баримт бичиг байхгүй, нэг сурах бичиг дагасан хөтөлбөр боловсруулсан байгаа нь эдгээр орнуудын баримталж буй бодлоготой төдийлөн уялдахгүй байна.

Ийнхүү Азийн орнуудын англи хэлний сургалтын бодлогыг авч үзвэл: улс орныхоо хөгжлийг хурдасгахын тулд англи хэлийг зааж байна, бусад соёлыг ойлгох үндсэн хэрэгслэл нь болж байна, глобалчлагдсан ертөнцийн олон улсын харилцааны хэрэгслэл болгох үүднээс англи хэлийг зааж байна

Хүснэгт 1 Азийн орнуудын их, дээд сургуулиудын англи хэлний үүрэг, мэргэжлийн англи хэлний сургалтын харьцуулсан судалгаа

Улс орнууд	Англи хэлний бодлого, сургалтын онцлог
Англи хэлийг хоёрдогч хэлээ болгон үзэж судалдаг улс орнууд	

Энэтхэг улс	<ul style="list-style-type: none"> • Шинжлэх ухааны зарим хичээлээ англи хэл дээр явуулдаг. • Англи хэл нь чухал, бас зиндаа тогтоох үүрэг гүйцэтгэдэг
Вьетнам	<ul style="list-style-type: none"> • Их, дээд сургуулиуд зарим хичээлийг англи хэлээл заах бодлогыг баримталдаг. • Англи хэлийг ажил мэргэжилдээ ашигладаг байх • Канадад боловсруулсан ном англи хэлдээ ашиглаж, багш нараа Британид бэлтгэдэг.
Малайз улс	<ul style="list-style-type: none"> • 2020 он гэхэд Малайз улс нь олон улсын харилцааны технологийн (ICT) дэвшилтэт түвшинд хүрэх алсын хараатай ажиллаж байгаа ба үүнд хүрэх үндсэн түлхүүр нь англи хэлний сургалт (ELT) хэмээн үзжээ. • 2003 оноос эхэлж бүх шатны сургуулиудад математик болон шинжлэх ухааны хичээлүүдийг англи хэл дээр явуулж байна.
Сингапур улс	<ul style="list-style-type: none"> • Англи хэлийг нэгдүгээр хэл гэж авч үздэг явдал юм. • Англи хэлийг олон улсын ажлын байрны хэл гэж тодорхойлсон. • Төрөлх хэлнээс бусад бүх хичээлүүд англи хэл дээр заагддаг.
Тайвани	<ul style="list-style-type: none"> • Азийн англи хэлний шилдэг сургалттай орон • Англи хэлний багш, тухайн мэргэжлийн багш нарын дунд өрсөлдөөн бий болсон
Англи хэлийг олон улсын зориулалтаар үзэж судалдаг улс орнууд	
Хятад улс	<ul style="list-style-type: none"> • “Мэргэжил+Англи хэл” гэсэн давхар мэргэжил эзэмших (dual degree) сургалтын шинэ загвар. • 2007 онд Хятадын Боловсролын Яам бизнесийн англи хэлийг албан ёсны хичээл болгон баталжээ.

Солонгос улс	<ul style="list-style-type: none">• Англи хэлийг олон улсын хэл гэсэн ойлголттой байдаг.• Англи хэлийг ердийн хичээлүүдээс хамгийн чухал хичээл гэж итгэдэг.
Япон улс	<ul style="list-style-type: none">• 2007 он-“Англи хэлтэй япон хүн” гэсэн хөтөлбөр.• Ерөнхий англи хэл, мэргэжлийн англи хэлийг хөгжүүлэх 4-4-4 гэсэн загвар.• 28 гишүүн бүхий мэргэжлийн англи хэлний хамтын нийгэмлэг.

Ийнхүү Азийн орнуудын англи хэлний сургалтын бодлогыг авч үзвэл 1. Үндэсний хөгжилөө хурдасгахын тулд Англи хэлийг зааж байна. 2. Бусад соёлыг ойлгох үндсэн хэрэгслэл нь болж байна. 3. Глобалчлагдсан ертөнцийн олон улсын харилцааны хэрэгслэл болгох үүднээс зааж байна.

Дүгнэлт

Дээрх улсуудын англи хэлний бодлогоос харахад их дээд сургуулиуд нь оюутнуудаасаа эрэлт хэрэгцээ шаардлагын талаар судалгаа авдаг, судалгааны төслүүд хэрэгжүүлдэг, багш нар нь төрөл бүрийн ажлын байран дээр очиж ажлын байрны англи хэлний дискурсийн судалгаа хийдэг, багш нарыг судалгаа хийхэд нь тэтгэлэг олгодог зэргээр мэргэжлийн англи хэлийг хөгжүүлэхийн тулд төрөл бүрийн дэвшилтэт бодлогуудыг баримтлан ажилладаг байна. Манай улсын хувьд ч гэсэн өөрийн орны онцлог, их дээд сургуулиудын сургалтын шинж чанар зэрэгт тохируулан мэргэжлийн англи хэлний их семинар зохион байгуулах зэргээр төрөл бүрийн арга хэмжээг авч мэргэжлийн англи хэлийг хөгжүүлэх нь зүйтэй байна.

English Language Spread and Development in Asian Countries

Munkhbayar Namsrajav

English Languages Department, Mongolian National University of Education

Ulaanbaatar, Mongolia

Abstract: Within this study we tried to explore spread of English, historical

development, implementing policy and future trends in English in Asian countries such as Singapore, Philippine, Khong Kong, Malaysia, Taiwan, Japan and Korea. This will help to determine future trends and English language education role of our country.

Keywords: English language development in Asian countries, language policy quality, language education role and future trends.

Ном зүй

1. Tollefson, W. (2013). *Language policies in Education*. p203
2. Graddol, D. (2010). *English next India: The future of English in India*. New Delhi: British Council.
3. Verna, R. (2008). *The service sector revolution in India: A quantitative analysis*. Research paper 2008/72
4. Барбара Е Жеймс. Хэл шинжлэлийн докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл . УБ., 2009.
5. (*ELT Documents 107: University of Malaya ESP Project*, 1980 for details of the project).
6. Munkhbayar N. Хэл шинжлэлийн докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл . УБ., 2016.
7. Rajagopal, M., & Williams, R. (1995). Visitron negotiations: A case study in materials adaptation. *ESP Malaysia*, 5 (1), 49-64.
8. Wenzhong Zhu, (2011), New developments of business English from ESP in China, *Theory and Practice in Language Studies*, 1(4), 379-383.
9. A series of Studies on English Education (13 Volumes), Volume 2. 2015.